

**“ХААН АЛТАЙ ХОВД” ХХК-ИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ /RAO/**

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ) “ХААН АЛТАЙ ХОВД ХХК” ХХК-ийн хэрэглэгчдэд түгээх сүлжээнд холбогдоход дараах техникийн нөхцөлийг хангасан байх шаардлагыг тавина.

Энэхүү нөхцөлийг Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын нэгдгүйгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний өрөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2.5 дахь хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

“ХААН АЛТАЙ ХОВД” ХХК нь Телевиз, радиогийн олон суваг дамжуулах №23410022 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд өөрийн Кабелийн телевизийн DVB-T2 технологиор Ховд аймагийн нутаг дэвсгэрт хүргэдэг.

**1. Сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага**

Телевизийн студиэс өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт	HD/SD форматаар SMPTE 292M (HD/SD)
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дүрсийн харьцаа	16:9
SD нягтрал	SD-SDI 625@50i
HD нягтрал	HD-SDI, 1080@50i шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264)
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих өренхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад болон EBU R128
Дууны кодлол	Стерео болон MPEG layer 2

**2. Зааглах цэгийн байршил, ашиглалт үйлчилгээ**

2.1 Сүлжээнд холбогдох зааглах цэгийн боломжит байршлуудыг дараах хүснэгтэд харуулав.

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)	Зааглах цэг дэх холболтын тоног төхөөрөмжийн мэдээлэл (нэр, брэнд, үндсэн үзүүлэлт гм)	Тайлбар
Байршил: /......./	“.....” ХХК-ийн байр, Optic receiver, Optic transmitter	Зааглах цэгт өөрийн сигналыг хүргэхтэй холбоотой сүлжээний турээс, татах, ашиглалт үйлчилгээг Телевизийн үйлчилгээ эрхлэгч хариуцна. /3 дахь этгээдээр гүйцэтгүүлж болох ба энэ тухайгаа ОСДҮЭ-д заавал мэдэгдэнэ/

2.2 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн студиэс зааглах цэг хүртэлх сүлжээг (сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэрэг) хариуцна.


2.3. Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь зааглах цэгийг дээр зааснаас өөр цэгт тогтоох саналтай бол хүсэлтийг албан бичигтээ тодорхой дурдаж, техникийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг ирүүлнэ.

Хэрвээ тус зааглах цэг нь Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын Хавсралт 4-д зааснаас өөр газарт байрлах бол албан бичгийн хувийг Зохицуулах хороонд илгээнэ.

#### 2.4 Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

ОСДҮ-ний сүлжээнд холбогдоход нэмэлтээр тоног төхөөрөмж шаардлагагүй.

#### 2.5 Холболтын схем, зураглал



#### 3. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл

Гэрээ хийх процесс, бусад асуудлаар хэнтэй харилцах тухай “Хавсралт-3”-д дурдсаны дагуу харилцан шуурхай мэдээлэл солилцож, шуурхай шийдвэрлэнэ.

#### 4. Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл

Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын 2.9-д заасны дагуу Харилцаа холбооны үйлчлэгч нь сүлжээнд холбогдох гэрээ байгуулах, төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөн зорилго агуулахгүй, мөн журмын 8-р хэсгийг баримтална.

<b>Зааглах цэг байрлах хаяг</b> (Хэрвээ холболтын төлбөр нь зааглах цэгийн байршилаас хамаарах бол тус бүрд нь бичнэ)	<b>Дамжуулалтын төлбөр</b> (тухайн TV-ийг өөрийн сүлжээнд холбоод гарах өртөгт сууринсан зардал байх ба орон нутаг болон Улаанбаатар хотын хувьд тус тусад нь гаргана.)	<b>Үндэслэл, тайлбар</b>
Байршил: Байршил нь .....” XXX-ийн Optic receiver, Optic transmitter	Гэрээний 6.1 заасны дагуу Нийлүүлэгч нь энхүү гэрээний хүрээнд суваг дамжуулалтын төлбөр төлөхгүй	Зааглах цэгээр дамжуулан хүлээн авч байгаа тул шаардлагагүй

#### 5. Гэрээний загвар

БАТЛАВ.  
“.....” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

БАТЛАВ.  
“ХААН АЛТАЙ ХОВД” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



### ХОЛБОЛТ, ДАМЖУУЛАЛТЫН ГЭРЭЭ

20.. оны ... дугаар сарын ...-ны өдөр

№

Улаанбаатар хот

#### Нэг: Гэрээ байгуулах үндэслэл, зорилго

- 1.1 Нэг талаас Улсын бүртгэлийн ..... регистрийн ..... дугаартай “.....” ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх-/ийг төлөөлж захирал ..... нөгөө талаас Улсын бүртгэлийн **1611002031** регистрийн **2610914** дугаартай “Хаан алтай ховд.” ХХК /цаашид “Дамжуулагч” гэх-/ийг төлөөлж захирал С.Төгөлдор хамтад нь “Талууд”, зарим тохиолдолд дангаар нь “Тал” гэх / нар нь Дэлхийн Худалдааны Байгууллагаас гаргасан Зохицуулалтын зарчмууд (Regulatory Principles Reference Paper /RPRP/), Харилцаа холбооны тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай болон бусад холбогдох хуулиуд, ХХЗХ-ноос батлагдан гарсан харилцан холболт, холболтын талаарх холбогдох журмууд болон тус тусын байгууллагын дүрэмд үндэслэн энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Нийлүүлэгч нь Дамжуулагчийн сүлжээнд холбогдох болон Дамжуулагч нь Нийлүүлэгчийн бэлтгэсэн “.....” телевизийн хөтөлбөрийг бүрэн хэмжээгээр, HD/SD форматаар хүлээн авч, “BEYOND MEDIA” үйлчилгээгээр Улаанбаатар хотын айл өрх, албан байгууллагад чанарын өндөр түвшинд хүргэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

#### Хоёр. “Нийлүүлэгч”-ийн эрх, үүрэг:

- 2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Дамжуулагч талаас шаардах эрхтэй.
- 2.2 Дамжуулагч талын сүлжээгээр дамжин хэрэглэгчдэд очиж байгаа өөрийн бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавих эрхтэй.
- 2.3 Нийлүүлэгч тал нь Дамжуулагч талын сүлжээний холболтод хавсралт-1 дэх шаардлага болон MNS 5592-2:2016 стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг гэрээний 4.4-т заагдсан, зааглах цэгээр дамжуулан шилэн кабелаар Дамжуулагч талд тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй.
- 2.4 Өөрийн нэвтрүүлгээ MNS 5592-2:2016 стандартын шаардлага хангахуйц түвшинд дамжуулж эфирийн сахилгыг сахиж, мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийн эх сурвалжийн үнэн бодит байдалд хяналт тавьж, эрх зүйн асуудлаа дангаараа бүрэн хариуцах үүрэгтэй.
- 2.5 Нийлүүлэгч нь өөрийн нэвтрүүлгийн хөтөлбөрийг үг үсгийн алдаагүй, хавсралт-4 дахь форматаар, Лхагва гараг бүр Дамжуулагчийн ..... и-мэйл хаяг руу урьдчилан илгээж, хөтөлбөрийн цагийг баримтлах үүрэгтэй.
- 2.6 Нийлүүлэгч нь холболтын төв болон зааглах цэгт өөрийн өмчлөлд хамаарах тоног төхөөрөмжтэй бол түүний засвар үйлчилгээг өөрөө хариуцах бөгөөд найдвартай, аваар осолгүй, ашиглалтын болон технологийн горимыг Дамжуулагч талаас хамааралгүй зохион байгуулж ажиллах үүргийг дангаар хүлээнэ.
- 2.7 Нийлүүлэгч нь “Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулийн 4.1.21, 26.5-д заасан хариуцлагыг биелүүлэхтэй холбоотой Дамжуулагч талын ажилд саад учруулахыг хориглоно.

#### Гурав. “Дамжуулагч”-ийн эрх үүрэг:

- 3.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Нийлүүлэгчээс шаардах эрхтэй.
- 3.2 Нийлүүлэгчийн нэвтрүүлгийг, зааглах цэгээр дамжуулан, техникийн шаардлага хангасан шилэн кабелиар, Дамжуулагчийн ..... хаягт байрлах HEADEND дээр хүлээн авч, “BEYOND MEDIA” үйлчилгээний хэрэглэгчдэд MNS 5592-2:2016 стандартын шаардлагын дагуу нийлүүлэгчийн ирүүлсэн сингалын түвшинг бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй.
- 3.3 Дамжуулагч нь зааглах цэг дэх өөрийн өмчлөлд хамаарах тоног төхөөрөмж, түүний ашиглалт үйлчилгээг өөрөө хариуцах бөгөөд найдвартай, аваар осолгүй, ашиглалтын болон технологийн горимыг Нийлүүлэгч талаас хамааралгүй зохион байгуулж ажиллах үүргийг дангаар хүлээнэ.

- 3.4 Дамжуулагч нь Нийлүүлэгчийн ирүүлсэн хөтөлбөрт өөрчлөлт оруулах эрхгүй ба зөрүүлснээс үүдсэн хариуцлагыг дангаар хүлээнэ.
- 3.5 Дамжуулах, хүлээн авах төхөөрөмжид гэмтэл гарсан, нийлүүлэгч тал байршилаа өөрчилсөн, зааглах цэгийн байршил өөрчлөгдсөн зэрэг шалтгааны улмаас холболтыг салгах, хязгаарлалт хийх тохиолдолд Зохицуулах хороонд болон нөгөө талдаа 72 цагийн өмнө үндэслэлийн хамт, дамжуулагч талын сүлжээний хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
- 3.6 Дамжуулагч нь Нийлүүлэгч талын бэлтгэн цацаж байгаа нэвтрүүлэг контент нь Монгол улсын хууль дүрэм, хориглосон үйл ажиллагааг зөрчсөн эсэх талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй ба хөтөлбөр дундуур аливаа хэлбэрийн зар, сурталчилгаа дамжуулахыг хориглоно.
- 3.7 Нийлүүлэгчийн дамжуулж буй сувгийг “BEYOND MEDIA” үйлчилгээний сувгийн багцад оруулж, хэрэглэгчдэд мэдэгдэх үүрэгтэй.

#### **Дөрөв. Хариуцлага:**

- 4.1 Талууд гэмтэл saat ал, засвар үйлчилгээ, хөтөлбөрийн өөрчлөлт, болзошгүй эрсдэлийг бууруулах болон бусад хэлбэрээр яярлтай холбоо тогтоо шаардлагатай бол “Хавсралт-3”-д дурдсан нөхцөлөөр харилцан шуурхай мэдээлэл солилцож, шуурхай шийдвэрлэнэ.
- 4.2 Талууд сар бүр холболтын тоног төхөөрөмжүүдээ урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ, хэмжилт хийх бөгөөд нөгөө талынхаа хүсэлтээр болон тусдаа, мөн хамтран хийж болно. Нөгөө талын сүлжээнд нөлөөлөхүйц төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажил үйлчилгээ гүйцэтгэх бол нөгөө талдаа ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэж дамжуулалтыг таслахгүйгээр хийхийг хамтран шийдвэрлэнэ.
- 4.3 Сүлжээний холболттой хамаатай гэмтэл saat ал, бусад засвар үйлчилгээг талууд 24 цагт багтаан засварлах ба 24 цагаас дээш хугацаа шаардлагатай бол агаарын болон бусад сүлжээгээр холбогдож, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- 4.4 Зааглах цэг нь ..... байранд байрлах “.....” ХХК-ийн өмчлөлийн Optic receiver, Optic transmitter бүхий “Холболтын төв” дэхь шилэн кабелийн хүлээн авагч байна. Зааглах цэгийг зургаар “Хавсралт-2”-т үзүүлэв.
- 4.5 Талууд гэрээний 4.4-т зааснаас өөр цэгт зааглах цэг тогтоолгох хүсэлт гаргалав ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлэх ба ХХЗХ шийдвэр гаргах хүртэл өмнө хэрэглэж байсан шийдэл, зааглах цэгээр үйлчилгээг тасралтгүй дамжуулах нөхцлийг бүрдүүлж ажиллана.
- 4.6 Зааглах цэг хүртэлх холболтын шилэн кабелийн түрээс, ашиглалт үйлчилгээг Нийлүүлэгч, Зааглах цэгээс HEADEND хүртэлх холболтын шилэн кабелийн түрээс, ашиглалт үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна.
- 4.7 Талууд зааглах цэг хүртэлх сүлжээг гуравдагч этгээдээс түрээслэх бол нөгөө талдаа заавал мэдэгдэж, харилцан зөвшүүлж шийдвэрлэнэ.
- 4.8 Гэрээнд оролцогч талуудын аль нэг нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талдаа учруулсан бодит хохирлыг төлөх үүрэгтэй. (Шууд бус хохирол буюу олох байсан ашгийг нөхөн олгохгүй)
- 4.9 Талууд Монгол улсын хуульд заагдсан байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүдэлтэй техникийн saat болон технологийн онцлогт сөргөөр нөлөөлөх цаг агаарын хүчин зүйлийн улмаас сигналын чанарт өөрчлөлт орох, тасрах нөхцөлд талууд харилцан үүрэг хүлээхгүй.
- 4.10 Дамжуулагч нь сувгийн дугаарлалтыг тогтооходо “Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулийн 26.7 болон гэрээ байгуулсан дарааллыг баримтлах тул ..... телевиз нь “Beyond Media” үйлчилгээний үндсэн багцын ..... -р суваг дээр байрлана. Нийлүүлэгчийн буруутай үйлдлээс шалтгаалж гэрээг түдгэлзүүлсэн, цуцалснаас үүдэн бусад сувгийн дугаарлалтад өөрчлөлт орохгүй ба тухайн сувгийн дугаарлалтыг дамжуулагчийн зүгээс бусад нийлүүлэгчид санал болгож болно.
- 4.11 Дамжуулагч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой реклам, зар сурталчилгаа, нэвтрүүлгийг Нийлүүлэгч талын төлөвийн харилцан тохиролцсоны үндсэн дээр дамжуулж болно.
- 4.12 Талууд сүлжээнд холбогдсоноос хойш гэнэтийн болон ослын нөхцөл байдал үүсэхээс бусад тохиолдолд холболтыг салгах, хязгаарлалт хийхийг хатуу хориглох ба гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлд гэрээний 7 дугаар зүйлийг баримтлана. Мөн ХХЗХ-ны зүгээс Нийлүүлэгчийн хөтөлбөрийг дамжуулахыг хориглосон, тусгай зөвшөөрлийг цуцласнаас бусад нөхцөлд сүлжээнд хязгаарлалт, салгалаа хийхийг хориглоно.

**Тав. Гэрээ цуцлах үндэслэл**

- 5.1 Гэрээнд оролцогч талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзсан, Гэрээний нөхцөл дуусгавар болсон тохиолдолд гэрээг цуцалж болно.
- 5.2 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах тухай мэдэгдлээ талууд 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгэн хэлбэрээр мэдэгдэх ба нөгөө тал нь 10 хоногийн дотор ямар нэгэн хариу өгөөгүй тохиолдолд гэрээ цуцлагдсанд тооцож болно.
- 5.3 Гэрээнд оролцогч талуудын аль нэгэнд дараах нөхцөл байдал үүсвэл гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
- 5.3.1 Цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон болон дампуурснаа албан ёсоор зарласан;
  - 5.3.2 Үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан, сунгахаас татгалзсан;
  - 5.3.3 Эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь зогсоо шийдвэр гарсан.

#### **Зургаа: Төлбөр тооцоо**

- 6.1 Нийлүүлэгч нь энхүү гэрээний хүрээнд суваг дамжуулалтын төлбөр төлөхгүй.
- 6.2 Талууд сүлжээнд холбогдсон шилэн кабелийн түрээс, түүний ашиглалт үйлчилгээний төлбөрийг гэрээний 4.6 болон 4.7-г баримтлан тус тусдаа хариуцна.

#### **Долоо: Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдгийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гэрчилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 7.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замbaraагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригтоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.
- 7.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

#### **Найм: Бусад**

- 8.1 Гэрээнд талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж 20... оны ... сарын ...-ний өдрөөс 20... оны ... сарын ...-ний өдрийг дуустал ... жилийн турш мөрдөгднө.
- 8.2 Гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд ямар нэг саналгүй бол ижил нөхцөлөөр, ижил хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 8.3 Гэрээг 3 хувь үйлдэн баталгаажуулж талууд тус бүр нэг хувийг хадгалах ба 1 хувийг “Сүлжээ хооронд харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-д заасны дагуу ажлын 10 хоногийн дотор талууд хавсралтуудын хамт гэрээ, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр ХХЗХ-нд хургүүлийг бүртгүүлнэ. Гэрээний хувь тус бүр хуулийн өмнө аидл, хүчин төгөлдөр байна.
- 8.4 Энхүү гэрээнд тусгагдсан аливаа мэдээлэл нь үнэн зөв байдлыг хангасан байх ба тус мэдээллийг бусдад задруулсантай холбоотойгоор нөгөө талын ажил үйлчилгээнд сөргөөр нөлөөлсөн бол мэдээллийг задруулсан этгээдэд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 8.5 Талуудын эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар болон Гэрээний хавсралт, талуудын баталгаажуулсан нэмэлт өөрчлөлт нь энхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 8.6 Гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудал гарвал талууд, эвлэрлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хороо болон Монгол улсын хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

#### **ГЭРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:**

“.....” ХХК

Хаяг: ..... байр  
Утас: .....  
Факс: .....

“.....” ХХК-ийг төлөөлж:

.....  
Утас: .....

“ХААН АЛТАЙ ХОВД” ХХК

Хаяг: Ховд аймаг Жаргалант  
сум Баатархайрхан баг Дэлхийн  
байгаль хамгаалах сангийн  
2давхарт

Утас 70432120 95612120  
Факс: .....

“Хаан алтай ховд” ХХК-ийг  
төлөөлж:  
Албан тушаал  
Захирал С.Манжур С.Төгөлдөр  
Утас: 99008882

... тоот гэрээний хавсралт-1

ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Холболт хийх техникийн нөхцөл:

- Холболт хийхэд шаардагдах техник төхөөрөмж, түүнд тавигдах шаардлага, стандарт үзүүлэлт зэрэг нь доор хүснэгтийн дагуу байх бөгөөд орсон өөрчлөлтийг тухай бүрд тусгаж байна.
- Телевизийн студиэс ирэх дохио нь Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих өрөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг хангасан байна.
- Талуудын сүлжээ хооронд холболт хийх дамжуулах шугам нь .....(өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ)..... байна.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт	HD/SD форматаар SMPTE 292M (HD-SDI)
Дууны оролт	Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дүрсийн харьцаа	16:9
SD нягтрал	SD-SDI 625@50i
HD нягтрал	MPEG/AVC (H.264)
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	MNS 5592-2:2016 стандарт болон EBU R128 зөвлөмжийг мөрдөнө
Дууны кодлол	MPEGlayer 2

Холболтын техник, техөөрөмжийн нэр, зориулалт	Телевиз талд	Дамжуулагч талд (ОСДҮЭ)
Хөрвүүлэх төхөөрөмж (Encoder) түүний төрөл, марк, серийл дугаар		NDS3208A MPEG-2 Super encoder 4ш
Дамжуулах (Tx) / Хүлээн авах (Rx) төхөөрөмж	Tx	Rx

түүний төрөл марк, серайл дугаар		
Холбох шугамын төрөл, үзүүлэлт	1 core fiber optic	1 core fiber optic
Холболтын интефэйс	HD-SDI	HD-SDI
Бусад		


.... тоот гэрээний хавсралт-2

### ЗААГЛАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ, ЗУРАГЛАЛ

Зааглах цэг:

- Зааглах цэг нь Дамжуулагч талын сүлжээний нэг хэсэг бөгөөд зааглах цэг дэх техник, төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээг Дамжуулагч тал хариуцна.
- Сүлжээний зааглах цэгийн байршил, холболтын зургалт нь доор заасны дагуу байна.

ЗААГЛАХ ЦЭГ, ТҮҮНИЙ ХОЛБОЛТ /дундын зааглах цэг/



.... тоот гэрээний хавсралт-3

ТАЛУУДЫН ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

ГЭРЭЭ, КОНТЕНТЫН АСУУДЛААР	
Дамжуулагч тал	Нийтийн алба
Марктенгийн Алба В.Очирзүл Утас: 99945427 e-mail: Ochirzul.88@gmail.com	Маркетингийн алба ..... Утас: ..... e-mail: .....
ТЕХНИКИЙН АСУУДЛААР	
Инженер Техникч Х.Болдсүх Утас: 85522120 e-mail: .....	Техникийн албаны дарга ..... Утас: ..... e-mail: .....
ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРЧЛӨЛТ, СУВГИЙН АСУУДЛААР	
Х.Болдсүх Утас: 85522120 e-mail: .....	Маркетингийн алба ..... Утас: ..... e-mail: .....

.... тоот гэрээний хавсралт-4

ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨР ИРҮҮЛЭХ ФОРМАТ

“ТВ нэр” ..... Телевизийн 20.... оны ...-рсарын .... – ны ..... өвлийн хотолбор

Эхлэх цаг	Дуусах цаг	Нэвтрүүлгийн нэр
08:00	08:05	
08:05	08:30	
08:30	09:00	
09:00	10:00	
10:00	11:00	
11:00	11:20	
11:20	13:00	
13:00	14:00	
14:00	14:10	
14:10	15:00	
15:00	15:30	
15:30	17:00	
17:00	17:30	
17:30	17:50	
17:50	18:00	
18:00	19:00	
19:00	20:00	
20:00	20:10	
20:10	21:00	